



**ДУНДГОВЬ АЙМГИЙН
ГЭР БҮЛ, ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУДЫН ХӨГЖЛИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 01 сарын 21 өдөр

Дугаар А/В

Мандалговь

**Н.Цэрэнгийн нэхэмжлэлд шинжээчийн
дүгнэлт гаргах тухай**

Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Сонгинохайрхан дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн 2019 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн 184/Ш32020/00119 дугаар шүүгчийн захирамжийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Н.Цэрэнгийн нэхэмжлэлтэй Э.Цэрэндондовт холбогдох гэрлэлт цуцлуулах, хүүхдийн асрамж тогтоох шинжээчийн дүгнэлт гаргах ажлыг 2020 оны 01 дүгээр сарын 21-ний өдрөөс 02 дугаар сарын 10-ны өдрийн дотор зохион байгуулсугай.

2. Шинжээчийн дүгнэлт гаргахад шаардагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3. Шинжээчийн дүгнэлт гаргахад шаардагдах 634470 (Зургаан зуун гучин дөрвөн мянга дөрвөн зуун дал) төгрөгийг Нийгмийн бүлэгт чиглэсэн хөтөлбөрөөс санхүүжүүлэхийг нягтлан бодогч (С.Чинбат)-д зөвшөөрсүгэй.

4. Тушаалын хэрэгжилтийг хангаж, үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг ажлын хэсгийн ахлагч, Хамтын ажиллагаа, сургалт сурталчилгаа, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн (Х.Мөнхсаруул), гишүүдэд үүрэг болгосугай.

5. Үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавьж, үр дүнг 2020 оны 02 дугаар сарын 25-ны өдрийн дотор даргын дэргэдэх зөвлөлд танилцуулахыг ажлын хэсгийн ахлагч, Хамтын ажиллагаа, сургалт сурталчилгаа, мэдээллийн сан хариуцсан мэргэжилтэн (Х.Мөнхсаруул)-д даалгасугай.

ДАРГА  Ц.ГАНЗОРИГ



48119001